Goldmt Capital®

# Хөрөнгийн зах зээлийн тойм

*Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв* 2022.05.30

## *Олон улсын хөрөнгийн зах зээл*

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## Онцлох индексүүдийн өөрчлөлт

*Дэлхийн томоохон индексүүдийг бүс нутгаар нь ангилан 7 хоног, сар, жилийн ханшийн өөрчлөлтүүдийг үзүүлэв. Үүнд АНУ-ын Dow Jones, S&P 500, Nasdaq, Германы Dax, Английн FTSE 100, БНХАУ-ын CSI 300, Хонг-Конгийн Hang Seng, Японы Nikkei 225 индексүүд багтана.*

| АНУ-ын индекс | Одоо | 7 хоногийн өмнөх | Өөрчлөлт | Сарын өмнөх | Өөрчлөлт | Жилийн өмнөх | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Dow Jones | $33,212.96 | $31,261.90 | 6.24% | $32,977.21 | 0.71% | $34,529.45 | -3.81% |
| S&P 500 | $4,158.24 | $3,901.36 | 6.58% | $4,131.93 | 0.64% | $4,204.11 | -1.09% |
| Nasdaq | $12,131.13 | $11,354.62 | 6.84% | $12,334.64 | -1.65% | $13,748.74 | -11.77% |

| Европын индекс | Одоо | 7 хоногийн өмнөх | Өөрчлөлт | Сарын өмнөх | Өөрчлөлт | Жилийн өмнөх | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Dax | € 14,462.19 | € 13,981.91 | 3.44% | € 14,097.88 | 2.58% | € 15,406.73 | -6.13% |
| FTSE 100 | £7,585.46 | £7,452.86 | 1.78% | £7,472.42 | 1.51% | £7,019.70 | 8.06% |

| Азийн индекс | Одоо | 7 хоногийн өмнөх | Өөрчлөлт | Сарын өмнөх | Өөрчлөлт | Жилийн өмнөх | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| CSI 300 | ¥4,001.30 | ¥4,077.60 | -1.87% | ¥4,026.24 | -0.62% | ¥5,321.09 | -24.80% |
| Hang Seng | HKD 20,697.36 | HKD 20,717.24 | -0.10% | HKD 21,089.39 | -1.86% | HKD 29,113.20 | -28.91% |
| Nikkei 225 | JPY 26,781.68 | JPY 26,739.03 | 0.16% | JPY 26,847.90 | -0.25% | JPY 29,149.41 | -8.12% |




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## *Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ*

### *ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ХҮЧТЭЙ НӨЛӨӨЛЖ БУЙ ОХУ, УКРАИНЫ ДАЙНЫ ЭРГЭН ТОЙРОНД*

*- Өнгөрсөн бямба гарагт ОХУ-аас Украины зүүн хэсэгт байрлах Лайман тосгоныг эзэлсэн гэж мэдэгдсэн бөгөөд одоогоор Украины Сиеверодонецк хот руу их бууны тусламжтайгаар эрчтэй довтолж байна.*

*- Украины нийслэл Киев хотыг эзлэхээр давшиж буй ОХУ-ын армийг зогсоохын тулд зам дагуу байрладаг Демыдив тосгоны даланг нурааснаар 50 орчим байшин үерт автсан гэж Украины амбан захирагч Олексий Кулеба мэдэгдэв.*

*- ОХУ-аас Бахмут, Соледар дахь Украины цэргийн хуаранг устгахын тулд пуужин харвасан бөгөөд хариу цохилт өгөхийн тулд Украин улс Дани болон АНУ-аас пуужин болон бусад зэвсгийг татаж эхэлсэн байна.*

*- Францын Ерөнхийлөгч Эммануэль Макрон, Германы засгийн газрын эрх баригч Олаф Шольц нар Оросын цэргүүдэд баривчлагдсан Азовсталь гангийн үйлдвэрийн 2500 Украин цэргийг суллахыг Путингаас шаардав.*

*- ОХУ-ын зүгээс Украиныг Хар тэнгис дэх боомтуудаар үр тариа тээвэрлэх боломжийг олгох талаар хэлэлцээр хийхэд бэлэн гэж мэдэгдээд байна.*

*- Даваагаас мягмар гарагуудад зохион байгуулагдах Европын Холбооны дээд хэмжээний уулзалтаар ОХУ-ын эсрэг ямар хориг арга хэмжээ авах талаар хэлэлцэнэ.*



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## ШАНХАЙД ТАВЬСАН ХӨЛ ХОРИОГ ХЭСЭГЧЛЭН ЦУЦАЛСААР БАЙНА

*БНХАУ ковидын эсрэг авч буй хатуу арга хэмжээг зөөлрүүлж, дэлгүүр, олон нийтийн тээврийн хэрэгсэл болон бусад газруудыг нээж байна.*

*Мөн Шанхай хотын удирдлагууд бизнес эрхлэгчдэд тавьсан хязгаарлалтыг 6 сарын 1ээс эхлэн цуцлэна гэж мэдэгдлээ.*

*БНХАУ-ын зарим бус нутгийн иргэд ойролцоогоор 2 сарын турш хөл хорионд байсны улмаас орлого олох боломжгүй байсан нь эдийн засагт хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байгаа юм.*

*Тиймээс энэ лхагва гарагаас эхлэн 25 сая хүнийг хөл хорионы дэглэмээс чөлөөлж байна.*

*Нэг үгээр хэлбэл БНХАУ-д ковидын нөхцөл байдал хүндэрсэн ч аль болох хэвийн амьдралдаа эргэн орох арга хэмжээг авч эхэллээ.*

*Мөн Шанхай хотоос эдийн засгаа дэмжихийн тулд автомашины татварыг бууруулах, орон нутгийн засгийн газрын бонд гаргах ажлыг түргэтгэх, үл хөдлөх хөрөнгийн төслүүдийн зөвшөөрлийг олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч эхэлжээ.*

*Шанхайн банкнуудаас энэ онд жижиг дунд бизнес эрхлэгчдэд нийт 100 тэрбум юань буюу 15 тэрбум ам.долларын зээл олгох төлөвлөгөөтэй байна.*

*"Бид үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийг сэргээхэд бүхий л талаар дэмжлэг үзүүлнэ" хэмээн тус хотын дэд дарга Ву Чин мэдэгдэв.*



# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд




## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.